



Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ны одрийн “Тогтоолын хавсралтад оорчлолт оруулах тухай” 94 дүгээр тогтоол гарч үндэсний энгийн гадаад паспортын сунгалтын бүртгэлийг зогсоохоор шийдвэрлэсэн. Гэвч Оюуны омч, улсын бүртгэлийн еронхий газрын 2017 оны тосовт 250,000 үндэсний энгийн гадаад паспортын бэлдэц худалдан авах санхүүжилт суугдсан. Гадаад паспортын сунгалтыг зогсоосон тохиолдолд бэлдэцийн нооц хүрэлцэхгүй зэргээс хамаарч Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ны одрийн 94 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах боломжгүй нохцол байдал үүссэн. Хэрэв 2017 оны дорөвдүгээр сараас эхлэн гадаад паспортын хугацааны сунгалтын үйлчилгээг зогсоосон бол 2018 оны 1-3 дугаар сард иргэнд гадаад паспорт олгох үйлчилгээний хэвийн байдал алдагдахаар байсан.

Тус газрын 2018 оны тосовт 300,000 үндэсний энгийн гадаад паспортын бэлдэцийн санхүүжилт суугдсан. 2017 оны 12 дугаар сарын 25-ны одрийн байдлаар үндэсний энгийн гадаад паспортын 116,000 бэлдэцийн нооц байгаа тул гадаад паспортын хугацааны сунгалтын үйлчилгээг зогсоосон ч 2018 онд гадаадад зорчих эрхийн бүртгэлийн үйлчилгээг хэвийн үзүүлэх боломжтой.

Иймд ООУБЕГ-ын даргын тушаалаар гадаад паспортын хүчинтэй хугацааны сунгалтын бүртгэл хотлох үйлчилгээг 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн зогсоолоо. Оороор хэлбэл, гадаад паспортын хугацаа нь дууссан тохиолдолд сунгуулахгүй, дахин шинээр авах юм.

2017 оны 12 дугаар сарын 25-ны одрийн байдлаар тус газар нь 336,550 гадаадад зорчих эрхийн бүртгэлийг хотолсон буюу 237,770 иргэнд шинээр гадаад паспорт олгож, 98,780 иргэнд гадаад паспортын хугацааны сунгалтын үйлчилгээг үзүүлэв.

Оюуны омч, улсын бүртгэлийн еронхий газар нь Гадаад хэргийн сайдын 2006 оны 42 тоот тушаалаар батлагдсан “Үндэсний энгийн гадаад паспортын загвар”-аар ХБНГУ-ын “Glesecke & Devirient” монго, үнэт цаасны үйлдвэрээс гэрээний дагуу бэлдэцийг хвлээн авч, “Титан Интернейшнл ХХК-иар үндэсний энгийн гадаад паспортын бичилтийг хийлгэж, Монгол Улсын иргэнд гадаадад зорчих эрхийн үйлчилгээг үзүүлдэг. ХБНГУ-ын “Glesecke & Devirient” монго, үнэт цаасны үйлдвэр нь гэрээний дагуу толбор хийгдсэнээс хойш 3 сарын хугацаанд үндэсний энгийн гадаад паспортын бэлдэцийг нийлүүлдэг.